

ТАНИЛЦУУЛГА

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөл

Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-д баримтат болон уран сайхны кино бүтээх эрх зүйн орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.42.3-т “Киноны тухай хуулийн төслийн боловсруулж батлуулах”-аар тус тус заасан.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл шаардлага болон Монгол киног дэлхийн зах зээлд өрсөлдүүлэх, кино үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх, кино урлагийн салбарыг эдийн засгийн хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх эрх зүйн орчин бий болгох зорилгоор “Кино урлагийг дэмжих тухай хууль”-ийн төслийг эцэслэн боловсруулсан байна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23.1-д зааснаар анхдагч хуулийн төсөл бөгөөд 6 бүлэг 15 зүйлтэй.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/244 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс салбарын уран бүтээлчид, эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөлд дараахь асуудлыг зохицуулахаар тусгасан:

1.төрөөс кино урлагийг хөгжүүлэх талаар бодлогын чиглэл, зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын эрх, үүргийг;

2.кино урлагийн мэдээллийн сан бүрдүүлэх, кино урлагийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд дараахь асуудлыг тусгасан:

-аливаа улс өөрийн соёлын аюулгүй байдал, салбарын хэмжээнд баримтлах бодлого, улс орноо сурталчлах үүднээс кино урлагийн хүчтэй нөлөөлөл, ач холбогдлыг ашиглах, үндэсний соёл, өвөрмөц онцлог, өв уламжлалыг эерэгээр харуулсан, монгол агуулга бүхий киног төрөөс дэмжих, кино урлагаар дамжуулан Монгол Улсыг сурталчлах талаар;

-“Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.2.46-т “Жил бүр үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхийн сэдэвтэй кино, тайз дэлгэц, утга зохиолын томоохон хэмжээний мэргэжлийн түвшний 1 бүтээл туурвих санхүүгийн дэмжлэг үзүүлнэ” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах

хүрээнд сонгон шалгаруулалт зарлах, төсвийн хөрөнгөөр бүтээх кинонд тавих шалгуур үзүүлэлийг тогтоохоор;

-Монгол киноны чанарыг сайжруулах, орчин үеийн техник технологийн ололт амжилтыг нэвтрүүлэх, уран бүтээлчдийг олон улсын чиг хандлага, арга барилд суралцах, кино зохиол, найруулагч, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх болон кино урлаг өндөр хөгжсөн орны сургалт, арга барил, сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх, нутагшуулах, уран бүтээлчдийн хөгжлийг дэмжих зохицуулалтыг.

3.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын кино үйлдвэрлэгч кино үйлдвэрлэх зорилгоор зураг авалт хийх үйл ажиллагааг зохицуулах, дотоодод телевиз, кино театраар кино түгээхэд баримтлах насны ангилал тогтоох шаардлага, нөхцөлийг;

4.хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалтыг төрөлжсөн хуулийн хүрээнд буюу Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар.

Хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.2.46.1-т “Жил бүр улсын захиалгаар түүхэн сэдэвт уран сайхны, бүрэн хэмжээний кино туурвих”-д улсын төсвөөс 1,5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор заасан тул хэрэгжилтийг хангаж жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэх шаардлага үүснэ.

Кино урлагийг дэмжих тухай хуулийн төслийг дагалдуулан, Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР